



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 4/14

Өмнөдэлгэр сум

Мэргэжлийн зэрэг олгох байнгын
ажлын хэсэг тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Боловсролын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/95 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Багшийн мэргэжлийн зэрэг шинээр авах болон бататгах баримт бичгийг нягтлан шалгах, үнэлэх, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ахлагч: Багшийн хөгжил хариуцсан сургалтын менежер

Гишүүд: Нийгмийн ухааны заах аргын нэгдлийн ахлагч

Байгалийн ухааны заах аргын нэгдлийн ахлагч

Бага ангийн заах аргын нэгдлийн ахлагч

Авьяас хөгжүүлэх заах аргын нэгдэл

Нийгмийн ажилтан

Нарийн бичгийн дарга: Үнэлгээ хариуцсан сургалтын менежер

2.Мэргэжлийн зэрэг олгохтой холбогдох үйл ажиллагааг журам, зөвлөмжийн дагуу зохион байгуулж, зэргийн шалгуур хангасан эсэх дүгнэлтийг багш нарын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж санал, хурлын тэмдэглэлийн хамт танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3.Мэргэжлийн зэрэг олгох шаардлага, шалгуур хангасан багш нарын холбогдох мэдээллийг боловсролын мэдээллийн нэгдсэн системд баталгаажуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ _____ Ж.СУГАРРАГЧАА

